

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 11/25


Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга томилох тухай


Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн
ТОГТООХ НЬ:


1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Данзан овогтой Даянбилгүүнийг томилсугай.


ЗӨВШӨӨРСӨН


 Б.ЛХАГВАДОРЖ


 Д.ДАЯНБИЛГҮҮН


 Н.БАТГЭРЭЛ


 Д.АМГАЛАНБАЯР

 Б.ЭНХБАЯР


 ХИТОЧИ ТАНИ

 УЛУЧ БИНГОЛ

 М.ТУЯА

 О.УРАНБАЙГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 12/25


Улаанбаатар хот

Компанийн Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай хуулийн 76.1.8 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Бүрэнмэнд овогтой Лхагвадоржийг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

БИДИСЕК ҮЦК" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 13/25


Улаанбаатар хот

Компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор бусад хуулийн этгээд, хувь хүнтэй хамтран 4,000,000,000 /дөрвөн тэрбум/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт хийх, эд хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах, хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдэд хөрөнгө оруулалт хийх, банкны зээлийн гэрээ, барьцааны гэрээ зэрэг банктай холбогдох бүхий л гэрээ болон бусад чиглэлээр гэрээ хэлцэл байгуулах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Лхагвадорж/-д олгосугай.
2. Энэхүү тогтоолын 1-д заасан гэрээ, хэлцэл нь Компанийн тухай хуулийн арван нэг, арван хоёрдугаар бүлэгт заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах бол хуульд заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлж байхыг Гүйцэтгэх захирал /Б.Лхагвадорж/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 14/25

Улаанбаатар хот


Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга томилох тухай

Компанийн тухай хуулийн 82.1 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн

2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргаар
Ганбат овогтой Энхжинг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ны өдөр

№ 15/25


Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын дэд хороог томилох тухай

Компанийн тухай хуулийн 81.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын дэд хорооны даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Б.Энхбаяр, гишүүдээр хараат бус гишүүн Хитоши Тани, ердийн гишүүн Н.Батгэрэл нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 16/25


Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хороог томилох тухай

Компанийн тухай хуулийн 81.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хорооны даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Д.Амгаланбаяр, гишүүдээр ердийн гишүүн О.Уранбайгал, хараат бус гишүүн М.Туяа нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 17/25


Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх дэд хороог томилох тухай

Компанийн тухай хуулийн 81.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бидисек ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн М.Туяа, гишүүдээр ердийн гишүүн Б.Лхагвадорж, хараат бус гишүүн Улуч Бингол нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 18/25


Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 23/02 тоот тогтоолыг Хавсралт №1-ийн дагуу баталсан БиДиСЕК ҮЦК ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журамд доорх нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Уг журмын хоёрдугаар хэсэгт “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалж, аль нэг хүйсийн эзлэх хувь гучаас доошгүй байхыг эрмэлзэнэ” мөн “Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, засаглалыг бэхжүүлэх зорилгоор ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино” гэх заалтыг тус тус нэмэлтээр оруулсугай.
3. Уг журмын гуравдугаар хэсэгт “Нэр дэвшүүлэх хорооны санаачилгаар компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлагатай агуулгын хүрээнд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөө болон сургалтыг компанийн зардлаар авах” гэх заалтын нэмэлтээр оруулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04-ний өдөр

№ 19/25

Улаанбаатар хот

Зээлийн гэрээ байгуулах, хөрөнгө барьцаалах тухай


Компанийн тухай хуулийн 76.1, 80.6 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 07 сарын 04-ний өдрийн санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. "БидиСЕК ҮЦК" ХК нь дараах нөхцөлийн дагуу "ХААН Банк" ХК-тай зээлийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

Үүнд:

- 1.1. Зээлийн төрөл: Зээлийн шугам
 - 1.2. Зээлийн дүн: 3,000,000,000 /гурван тэрбум/ төгрөг
 - 1.3. Зээлийн хугацаа: 12 /арван хоёр/ сар
 - 1.4. Зээлийн хүү: жилийн 16 /арван зургаа/ хувь
 - 1.5. Коммитмент хүү: 0 /нойл/ хувь
2. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар БидиСЕК ҮЦК ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгүүдийг барьцаалахыг зөвшөөрсүгэй.
 3. Дээрх зээлийн гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад БидиСЕК ҮЦК ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг БидиСЕК ҮЦК ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Лхагвадорж-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/